

Нийлүүлэгдэх бараа нь дор дурдсан техникийн тодорхойлолт, шаардлагад нийцсэн байна.

1. Нийлүүлэгч нь хамгийн бага үнээр улирлын нөхцөлд тохирсон 4 төрлийн / А-80, АИ-92, АИ-95 дизель түлш/ шатахууныг тухайн үеийн зах зээлийн жишиг үнээр худалдан авагч талд **жилийн туршид** бэлэн бус хэлбэрээр /карт болон талоноор/ олгох.
2. Карт болон талоны харьцааг шалгарсан компанитай гэрээ байгуулах шатанд тохиролцох бөгөөд эдгээрийн үнэ, холбогдон гарах зардал нь тендерийн санал болгосон үнэд багтсан байна.
3. Нийлүүлэх авто шатахуун нь ОХУ-ын ГОСТ Р 51105-97 стандартын дагуу үйлдвэрлэгдсэн болон түүнтэй дүйцэхүйц чанар стандартыг хангасан байна. Өөр гарал үүсэлтэй бараа нийлүүлэх тохиолдолд тухайн барааг үйлдвэрлэсэн стандарт нь Монгол улсын MNS 217:2006 стандартыг хангаж байгааг нотолсон бичиг заавал ирүүлнэ.
4. Нийлүүлэгдэх бараа **“А-80, АИ-92, АИ-95 ДТ”** нь үйлдвэрийн болон бусад шалгалт, туршилтын жагсаалтыг холбогдох мэдээллийн хамт ирүүлнэ. Холбогдох стандартад нийцэж байгааг болон түүнээс илүүгээр хангаж байгааг харуулсан дагалдах бичгүүдийг заавал хавсаргана.
5. Шатахууныг жилийн туршид тасралтгүй хангах бөгөөд зах зээл дээр шатахууны хомсдол гарсан нөхцөлд гэрээт байгууллагын үйл ажиллагааг зохих түвшинд хангах шатахууны нөөцтэй байх.
6. ШТС нь “УБЦТС” ТӨХК –ийн төв гараж, Хэрэглэгчдэд үйлчлэх төвүүд, Түгээх төвүүдийн ойрхон байршилтай байх бөгөөд ШТС–ын нутаг дэвсгэрийн байршлыг тодорхой харуулсан газрын зураг ирүүлнэ. Тус газрын зургийг үнэлгээнд харгалзан үзнэ.
7. УБЦТС ТӨХК –ийн Төв аймаг, Налайхын хэрэглэгчдэд үйлчлэх төв, түгээх төвүүдтэй ойр байршилтай байх шаардлагатай.
8. Нийлүүлэх барааны нэгж үнийн санал ирүүлнэ.
9. Нийлүүлэгч тал нь сар бүр ШТС –д түгээж байгаа шатахуун, тосны дээжийг итгэмжлэгдсэн лабораториор шинжлүүлж дүнг гаргуулсан байх. Шаардлагатай тохиолдолд газар дээр нь итгэмжлэгдсэн шинжээчийг дуудаж дээж авч тухайн шатахууны сорилыг тодорхойлно.